

# ХӨДӨӨ АЖ АХУЙН МЕНЕЖМЕНТ, ЭКОСИСТЕМИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ (STREAM) ТӨСӨЛ

## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Дэлхийн дулаарлын нөлөө Монгол оронд эрчимтэй ажиглагдаж, агаарын дундаж температур сүүлийн 70 гаруй жилд 2.2°C-аар нэмэгдэн хур тунадасны хэмжээ буурсан байна. Агаар мандлын гаралтай аюултай болон гамшигт үзэгдлийн тоо ихсэж, 1990-2000 онд жилд дунджаар 30 орчим аюултай үзэгдэл ажиглагддаг байсан бол 2001-2016 онд даруй 2 дахин нэмэгджээ. Эдгээр уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс гадна улсын хэмжээнд газрын талаар баримтлах нэгдсэн бодлого, төлөвлөлт хангалттай түвшинд хүрч чадаагүйгээс салбар хоорондын уялдаа алдагдаж тус тусдаа бодлого, үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг болсноор газрын үнэ цэнэ алдагдаж, зохицуулалтгүй ашиглалтаас үүдэлтэй агаар, хөрс, усны бохирдол, хүн амын хэт төвлөрөл, замын түгжрэл, бэлчээрийн доройтол, цөлжилт, газрын маргаан, зөрчил, ядуурал зэрэг байгаль орчин, нийгэм, эдийн засгийн олон асуудлууд үүссэн байна.

## ЗОРИЛГО:

Монгол улсад хүнсний тогтолцоо, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд шинэлэг, тогтвортой, ландшафтын түвшний менежментийг хэрэгжүүлэх чадавхыг нь нэмэгдүүлэхэд оршино. Төслийн зорилтууд нь:

- I. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон хөдөө аж ахуйн менежментийг хөгжүүлэх замаар, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж, тогтвортой байдлыг сайжруулж, нэмүү өртөг шингээхэд дэмжлэг үзүүлнэ.
- II. Зорилтот сумдын ойн нөөцийн тогтвортой менежмент, биологийн олон янз байдлыг хэвээр хадгалах чадавхыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.



## ЗОРИЛТОТ ГАЗАР НУТАГ

Хамтран санхүүжүүлэгч	Европын Холбоо:  Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахын төлөөх түншлэл/Хөдөө аж ахуйн судалгаа хийх замаар ухаалаг инновацыг хөгжүүлэх хүрээнд (GCCA+/DeSIRA): 4,150,000 евро  ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам (BMZ)-ны санхүүжилт: 400,000 евро
Хамтран хэрэгжүүлэгч	Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)  НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (FAO)
Зорилтот газар нутаг	Сэлэнгэ аймгийн Ерөө, Мандал, Жавхлант сум  Хэнтий аймгийн Биндэр, Баян-Адарга, Өмнөдэлгэр сум
Хэрэгжих хугацаа	2021 – 2024



Бид тогтвортой хөгжлийн дараах зорилгуудад хувь нэмэр оруулж байна:



## ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ



Сэлэнгэ аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон тус аймгийн 17 сум, мөн Хэнтий аймгийн Биндэр сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө аймаг, сумдын ИТХ-аар батлагдав.



Улсын хэмжээний тариалангийн газрын зураглалыг төслийн дэмжлэгээр гүйцэтгэснээр, тариалангийн газрын эргэлтэд оруулах боломжтой 226 мянга га талбайг тодорхойлж, ХХААХҮЯ-нд хүлээлгэн өгөв.



Махны гарц, чанарыг дээшлүүлж, малыг зах зээлд эрт борлуулах зорилгоор 100 өрхийн 1,080 үнээ, 668 хонинд зохиомол хээлтүүлэг хийж, хээл авалт дунджаар 77% байлаа.



Малчид малаа эдийн засгийн эргэлтэд эрт оруулах боломж бүрдэж, 400 орчим бяруу, 250 гаруй хургыг зах зээлд борлуулж, өрхийн орлогоо нэмэгдүүллээ. Мөн энэ тоогоор малын бэлчээрт үзүүлэх дарамтыг бууруулахад хувь нэмэр оруулав.



Малын шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлж, малдаа тарга хүч авахуулах, эрүүлжүүлэх угаалгад 90 малчин өрхийн 51,000 гаруй бог мал хамрагдав.



Орон нутагт малын тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Хангай Миллс ХХК-тай хамтран байгуулсан тэжээлийн үйлдвэр 80 гаруй тонн эрдсийн долооц үйлдвэрлэж, борлууллаа.



Төрөл бүрийн тэжээлийн жор боловсруулахад дэмжлэг үзүүлснээр 2 төрлийн 50 гаруй тонн багсармал тэжээл үйлдвэрлэж, зах зээлд нийлүүлсэн байна.



Малчдын санаачилгаар 2 хоршоо байгуулагдаж 9 хүнийг түр ажлын байраар хангаж, 14 тонн дайвар болон бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулав.



Агро-ойн загвар 5 аж ахуйн 71 га хүнсний ногооны талбайг хамгаалах, элсний нүүдлийг зогсоож, хөрсний элэгдэл, газрын доройтлыг бууруулах зорилгоор 11,600 мод, суулгац тарив.



Сэлэнгэ аймгийн Мандал суманд байрлах хүнсний ногооны агуулах ашиглалтаа 10 хувиар нэмэгдүүлж, 350-400 тонн ногоо хадгалах боломжтой болсноор хүн амыг шинэ, аюулгүй хүнсээр хангах, сумын тариаланчид орлогоо нэмэгдүүлэх боломжтой боллоо.



Мал аж ахуй, агро-ойжуулалт, газрын менежмент, агро-экологи, хоршоог хөгжүүлэх чиглэлээр сургалт зөвлөгөөн зохион байгуулж, 4,300 малчин, тариаланч, нутгийн захиргааны холбогдох албан тушаалтнуудын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэв.



Агроэкологийн олон улсын туршлагаас суралцаж, мэдлэг мэдээллээ нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх "Агроэкологийн өдөрлөг"-т 320 гаруй багш, оюутнууд оролцов.

## ОЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын санаачилгаар STREAM төслийн дэмжлэгтэйгээр Ойн тухай хуулийг шинэчлэн найруулах ажлыг эхлүүлэв.



Ойн мэргэжилтнүүдээс бүрдсэн баг Бүгд Найрамдах Чех Улсад айлчилж, орчин үеийн мод боловсруулах технологи, мод үржүүлгийн газрын үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлав.



"Нэг тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулж, сургалтын гарын авлага, тараах материалыг бэлтгэхэд хувь нэмэр оруулав.



Ойгоос гаралтай бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээний үнэлгээг хийж, цаашид хөгжүүлэх боломжит бүтээгдэхүүнүүдийн нэр төрлийг тодорхойлов.



Ойн салбарын бодлогын дүн шинжилгээ, ойн нэмүү өртгийн сүлжээн дэх МСҮТ-ийн салбарын үнэлгээг боловсруулж, Ойн газар болон ойн салбарын бусад оролцогчдод шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор хүргүүлэв.



Менделийн их сургуулиар ахлуулсан Их сургуулиудын консорциумтай хамтран байгуулсан 87 туршилт, судалгааны талбайд ойн аж ахуйн зарим арга хэмжээг загвар байдлаар хэрэгжүүлж байна.



Ойн салбарын олон улсын болон үндэсний 150 мэргэжилтнүүд "Ойн судалгаа, бодлогын шинэчлэл" сэдэвт зөвлөгөөнөөр чуулж, ойн хэрэглээний судалгааны үр дүнгийн талаар мэдээлэл солилцов.



Сэлэнгэ аймгийн Жавхлант суманд голын эрэг дагуух ойг нөхөн сэргээх, цаашлаад усны чанарыг сайжруулах зорилгоор хамгаалалтын зурвас байгуулав.



Сэлэнгэ аймгийн Жавхлант суманд байгуулсан мод үржүүлгийн газарт 16,000 ширхэг мод тарьж, ургуулж байна. Тус үржүүлгийн газар нь орон нутгийг тарьц, суулгацаар хангах төдийгүй, иргэдийг мод тарих практик сургалтад хамруулах зорилготой юм.



Орон нутагт зохион байгуулсан ОТМ-ийн сургалтуудаар сум дундын ойн анги, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагын нийт 614 оролцогчдыг чадавхжуулав.



Ойн аж ахуйн арга хэмжээг түгээн дэлгэрүүлэх зорилгоор зорилтот сумдад 160га талбайд ойн арчилгааны ажлыг дэмжсэнээр ойн нөхөрлөлүүдийн арчилгаа хийж гүйцэтгэх чадавх сайжрав.



Төслийн зорилтот газруудад ОТМ-ийн сайн туршлагыг цогцоор хэрэгжүүлэх Загвар ой санаачилгыг боловсруулав.



Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох арга хэмжээний ач холбогдлыг таниулах зорилгоор нөлөөллийн үйл ажиллагаануудыг зохион байгуулж, 24,500 хүнд хүрч ажиллав.



Хөгжөөнт тоглоомоор дамжуулан хүүхэд, залууст ойн модны ач холбогдлыг ойлгуулах зорилготой "Ойчидтой нэг өдөр" нөлөөллийн арга хэмжээг Сэлэнгэ, Хэнтий аймагт үе шаттайгаар зохион байгуулж, 250 хүүхдийг хамруулав.

## ХОЛБОО БАРИХ:

Монгол улс дахь Европын Холбооны төлөөлөгчийн газар

☎ +976 75115000

✉ [delegation-mongolia@eeas.europa.eu](mailto:delegation-mongolia@eeas.europa.eu)

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага

☎ +976 11 310248

✉ [amgalan.ariunbold@fao.org](mailto:amgalan.ariunbold@fao.org)

Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)

☎ +976 11 312282

✉ [michael.trockenbrodt@giz.de](mailto:michael.trockenbrodt@giz.de)



Цахим хувилбар: